



# МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ БА ДУУСААГҮЙ ОРХИГДСОН БАРИЛГУУДЫН САНХҮҮЖИЛТ



- 2019 оны төсөвт шинээр тусгаж, 2020 онд дуусгахаар төлөвлөсөн нийт 1.3 их наяд төгрөгийн өртөг бүхий 359 ажлаас 135.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий дөрвөн ажил 2020 оны төсвийн төсөлд тусгагдаагүй байна.
- Үндэсний аудитын газрын 2018 оны аудитад сонгогдсон дуусаагүй орхигдсон 46 барилгын 32 нь 2020 оны төсөвт мөн тусгагдаагүй.
- Гэтэл дээрх төслүүдийг дуусгахын оронд 2020 онд шинээр 626 төсөл эхлүүлж, 610 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төсвийн төсөлд суулгажээ.

## АЖИЛ НЬ ЭХЭЛСЭН 4 2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСАГДАЛГҮЙ ҮЛДСЭН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ



2019 ОНД  
ЭХЛҮҮЛЖ, 2020  
ОНД ДУУСГАХААР  
ТӨЛӨВЛӨСӨН  
БОЛОВЧ 2020  
ОНЫ ТӨСӨВТ  
ТУСААГҮЙ 4 АЖИЛ  
**(САНХҮҮЖҮҮЛБЭЛ  
ЗОХИХ ДҮН 122  
ТЭРБУМ ТӨГРӨГ)**



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН 2018 ОНЫ АУДИТАД  
ХАМРАГДСАН ДУУСААГҮЙ ОРХИГДСОН 46 БАРИЛГА,  
БАЙГУУЛАМЖИЙН **32 НЬ 2020 ОНЫ ТӨСӨВТ  
ТУСААГҮЙ**



АУДИТАД СОНГОГДСОН ШАЛГУУР


1

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2008 оноос хойш баригдаж эхэлсэн боловч санхүүжилт нь зогссон

2

Барилга угсралтын ажил дуусаагүй, ашиглалтад оруулаагүй, 3 ба түүнээс дээш жил үргэлжилж байгаа

## 2020 ОНД ШИНЭЭР ЭХЛЭХ ТӨСЛҮҮДИЙН САНХҮҮЖИЛТ

















2020 онд шинээр эхлүүлэх төслүүдийн нийт төсөвт өртгийн 42 хувийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.



2018 оны аудитад хамрагдсан дуусаагүй орхигдсон 46 барилга, байгууламжаас 2020 оны төсөвт 14 нь туссаны дотор 11-ийнх нь төсөвт өртөг нэмэгджээ.

## 2020 ОНЫ ТӨСӨВТ ТУССАН ТӨСЛҮҮДИЙН ЖАГСААЛТ

(тэрбум төгрөг)

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР	ЭХЭЛСЭН ОН	АНХНЫ ТӨСӨВТ ӨРТӨГ	2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУССАН ТӨСӨВТ ӨРТӨГ	ТӨСӨВТ ӨРТГИЙН ӨӨРЧЛӨЛТ	2020 ОНД САНХҮҮЖИХ ДҮН
 Ханхэнтий чуулгын барилга (Хэнтий, Хэрлэн сум)	2011	8.19	11.46	3.27	3.11
 Төрөх эмнэлэг, 50 ортой (Дорноговь, Сайншанд сум)	2011	1.72	8.27	6.55	2.35
 220 кВ-ын Сонгино дэд станцаас 110 кВ-ын Зайсан дэд станц хүртэлх 110 кВ-ын 44 км, хоёр хэлхээт ЦДАШ-ын ажлын зураг, барилга угсралтын ажил (УБ)	2012	9.00	9.34	0.34	0.60
 УБ хотын «Сонгино» 220/110/35 кВ-ын 2x125 МВа дэд станц, 220 кВ-ын 5.8 км цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил (УБ)	2012	19.50	21.60	2.10	3.40
 ХАА-н их сургуулийн МСҮТ-ийн хичээлийн байр (Орхон, Баян-Өндөр сум)	2013	2.16	4.91	2.75	4.61
 Хүүхэд, залуучуудын соёл, үйлчилгээний цогцолбор, усан бассейн байгуулах (Архангай, Эрдэнэбулган сум)	2013	1.76	2.45	0.68	0.68
 Сумын төвийн шинэчлэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эмнэлэг, 100 ортой (Дорноговь, Замын-Үүд сум)	2013	5.00	6.36	1.36	1.20
 Дулааны цахилгаан станц 4-өөс У-18 хүртэлх (Москва хорооллын урд тал хүртэл) 4.2 км, ф 800-ийн голчтой дулааны шугамын барилга угсралтын ажил (УБ)	2014	16.99	16.99	0.00	1.80
 «Төв халх» дуулалт жүжгийн театр (Дундговь, Сайнцагаан сум)	2011	6.80	6.80	0.00	2.78
 Спорт цогцолборын барилга (Дорноговь, Хатанбулаг сум)	2012	0.91	1.11	0.20	0.25
 Соёлын төвийн барилга, 250 суудалтай (Баянхонгор, Бууцагаан сум)	2008	0.66	1.90	1.24	1.50
 Дүүргүүдийн прокурорын нэгдсэн байр (УБ, ХУД)	2013	16.00	18.93	2.93	4.50
 Усан бассейн, спорт цогцолборын барилга (Баянхонгор, Баянхонгор сум)	2014	0.90	9.00	8.10	2.00
 Хилчин хотхоны инженерийн шугам сүлжээ (УБ, СХД, 30-р хороо)	2013	5.80	2.80	-3.00	1.23



## 2020 ОНД ДУУСГАХ БАЙСАН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

2019 онд эхэлж, 2020 онд дуусгах байсан дараах дөрвөн төсөл ирэх оны төсвийн төсөлд тусгагдаагүй.

(тэрбум төгрөг)

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР	ТӨСӨВТ ӨРТӨГ	2019 ОНД САНХҮҮЖИХЭЭР БАТЛАГДСАН ДҮН		2020 ОНД САНХҮҮЖИХ БАЙСАН ДҮН
	ТЭРБУМ ТӨГ	ТЭРБУМ ТӨГ	(НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГТ ЭЗЛЭХ ХУВЬ)	ТЭРБУМ ТӨГ
 Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 60 км (Төв, Мөнгөнморьт сум)	48	5	10%	43
Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Ихтамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км (Архангай)	69	5	7%	64
 Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ортой (Баян-Өлгий, Өлгий сум)	8.8	2.5	28%	6.3
Сүрьеэгийн эмнэлгийн барилга (УБ)	10	1	10%	9
<b>НИЙТ ДҮН</b>	<b>135.8</b>	<b>13.5</b>		<b>122.3</b>

Дээрх дөрвөн барилга, байгууламжийн гуравт нь эхний жилдээ 10 ба түүнээс бага хувийн, харин нэгд нь 30 хүрэхгүй хувийн санхүүжилтийг олгожээ.

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН 2018 ОНЫ АУДИТАД СОНГОГДСОН ДУУСААГҮЙ ОРХИГДСОН 46 БАРИЛГААС 2020 ОНЫ ТӨСӨВТ ТУСГАГДААГҮЙ 32 БАРИЛГА (ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААР)

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	ТӨСЛИЙН ТОО
Барилга, хот байгуулалтын сайд	14
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	7
Эрчим хүчний сайд	3
Бусад төсөв захирагч	8



Барилга, хот байгуулалтын сайдын багцад хамаарах дуусаагүй орхигдсон барилга, байгууламжуудаас 14-ийнх нь санхүүжилт 2020 оны төсөвт тусгаагүй байгаа нь уг төслүүдийг дуусгах талаар салбарын сайд дорвитой арга хэмжээ авч ажиллахгүй байгааг харуулж байна.



Үндэсний аудитын газрын 2018 оны аудитад хөдөө орон нутгийн 27 дуусаагүй орхигдсон барилга, байгууламж хамрагдсанаас 18-ын санхүүжилт 2020 оны төсөвт тусаагүй байна. Энэ нь дуусаагүй орхигдсон төслүүдийг гүйцээх талаар төсвийн ерөнхийлөн захирагчид дорвитой арга хэмжээ авч ажиллахгүй байгааг харуулж байна.

## АЙМГУУДАД БАЙГАА ДУУСААГҮЙ, 2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД САНХҮҮЖИЛТ ТАВИГДААГҮЙ 18 БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ (АЙМГААР)



### БАЯНХОНГОР

- Бага сургуулийн шинэ барилга, Бууцагаан сум
- Аймгийн төвийн 2 км автозам, Баянхонгор сум

### ГОВЬ-АЛТАЙ

- Сумын төвийн шинэчлэл төсөл, Дэлгэр сум
- Соёл амралтын хүрээлэн байгуулах, багц 3-усан оргилуур, усан хангамжийн ажил

### ДОРНОГОВЬ

Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх соёл, спортын цогцолборын барилга, 700 суудалтай, Замын-Үүд сум

### ДОРНОД

- Сумын төвийн шинэчлэлт төсөл, Баян-Уул сум

- Спорт цогцолборын өргөтгөл, усан бассейн, Хэрлэн сум

### ЗАВХАН

ЗДТГ-ын контор, Их-Уул сум

### УВС

"Боршоо" Олон улсын худалдааны төвийн барилга угсралтын ажил, Давст сум

### ӨМНӨГОВЬ

Барилгын материалын лабораторийн барилга, Даланзадгад сум

### СУХБААТАР

- Спорт цогцолборын барилга, 700 суудалтай, Баруун-Урт сум
- Сумын төвийн шинэчлэл, Эрдэнэцагаан сум

### СЭЛЭНГЭ

- Гэр хорооллын бохир усны 2.4 км шугам, Сайхан сум
- Үйлчилгээний төвийн барилга, Ерөө сум
- Соёлын төв, захирагчийн албаны барилга, Орхонтуул сум
- Шонхор хүүхдийн зуслангийн Соёлын төвийн барилга, Мандал сум

### ХӨВСГӨЛ


Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ баригдах 800 айлын цэвэр усан хангамж, ариутгах татуургын ИШС-ний барилга угсралтын ажил, Мөрөн сум

### ХЭНТИЙ

Сумын төвийн шинэчлэл, Биндэр сум



Нийслэлд 91.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 дуусаагүй орхигдсон барилга, байгууламж 2020 оны төсөвт тусгагдаагүй байна.



### СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГ

- СХД-ийн 10-р хороо, Усан хангамж ф32/150мм-ийн 871 метр шугам, ариутгах татуургын ф300мм-ийн голчтой 1246 метр шугамын угсралтын ажил
- СХД-ийн 10-р хороо, Дулааны ф65/200мм-ийн голчтой 924 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил

### СҮХБААТАР ДҮҮРЭГ

- 15-р хорооны Ахмадын сувиллыг өргөжүүлж өвлийн барилга байгууламж барих ажил

### БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ

- Хог боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах ажил
- Эмнэлгийн барилга, 10 ортой (Хонхор тосгон)

- 126-р сургуулийн барилга, 640 суудалтай

- 14-р хорооллын ус дулаан дамжуулах төв 4 ш, ф200/300мм-ийн 1134 метр, ф125/250мм 2239 метр шугамын зураг төсөв, барилга угсралтын ажил

- 14-р хорооллын бохир усны ф200/300мм ийн 1128 метр, ф300 мм-ийн 1185 метр шугамын зураг төсөв, барилга угсралтын ажил, Цэвэр усны ф150-250 мм-ийн 2103 метр, ф125/200 мм ийн 1065 метр шугамын зураг төсөл, барилга угсралтын ажил

### ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ

61-р сургуулийн спорт заалны барилга

### ХАН-УУЛ ДҮҮРЭГ

Дүүргүүдийн шүүхийн нэгдсэн байр

### УЛААНБААТАР ХОТ

- Улаанбаатар хотын бохир усны Туул-1 коллекторын шугам угсралтын ажил
- Ирээдүй цогцолбор хорооллын дулааны 4100 метр гол шугам, 6 ширхэг дулаан дамжуулах төвийн зураг төсөл, барилга угсралтын ажил
- 12 а магистралийн ТК-1211 цэгээс урагш гарсан 2 ф 400 мм голчтой шугамыг 2 ф 500 мм болгон өргөтгөх, 3\*500\*70 хүчин чадалтай шинээр даралт өргөх насос станц барих, зургийн хамт
- Хаалттай хуваарилах байгууламж 7-ийн өргөтгөл, 2-р үе шатны ажил